

БАТЛАВ

БАТЛАВ

БАТЛАВ

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН
ШАДАР САЙД БӨГӨӨД
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙД

САНГИЙН САЙД

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Н.УЧРАЛ

Б.ЖАВХЛАН

Л.МӨНХБААТАР

2025 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

/Анхдагч хууль/

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогод “...эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.” гэсэн зорилгыг дэвшүүлж, “бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх” замаар 2030 он гэхэд хүрэх зорилтыг тавьсан байдаг.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3 дугаар бүлэг “ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО” хэсэгт “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлнэ.” гэж, 3.1-д заасан “ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ” хэсгийн 3.2.2.1-т “Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэгчийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, 3.2.2.3-т “Шинэ аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгаж, гарааны компаниудын бизнесийг дэмжих экосистемийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, монополын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэж, 3.2.2.4-т “Төрийн байгууллагуудаас зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, зөвшөөрлийн нэгдсэн платформыг эхлүүлнэ.” гэж тус тус заасан.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг баталгаажуулах, Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор энэхүү Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулна.

1.2 Практик шаардлага

Дэлхийн өв уламжлалын сангаас “Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс”-ийг нийт 4 бүлэг 12 шалгуур үзүүлэлт ашиглан тооцдог бөгөөд Монгол Улс 2024 онд нийт дүнгээрээ 176 улсаас 60.6 оноотойгоор 76 дугаар байранд эрэмбэлэгдсэн ба V децилд байна.

Бүлэг	Шалгуур үзүүлэлт/дэд хүчин зүйлс	Оноо	Онооны ангилал	Байр
Засаглалын үр ашиг	Өмчийн эрх	48.8	муу	92/176
	Шүүхийн үр ашиг	34.8	бага	71/176
	Төрийн зарчимт байдал	55.0	муу	117/176
Засгийн газрын хэмжээ	Татварын дарамт	84.0	бүрэн	59/176
	Засгийн газрын зарлага	62.0	дунд	113/176
	Төсвийн сахилга бат	64.3	дунд	83/176
Зохицуулалтын үр ашигтай байдал	Бизнесийн эрх чөлөө	68.0	дунд	79/176
	Хөдөлмөрлөх эрх чөлөө	67.5	дунд	24/176
	Мөнгөний эрх чөлөө	67.9	дунд	117/176
Нээлттэй зах зээл	Худалдааны эрх чөлөө	74.4	сайн	72/176
	Хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал	50	бага	119/176
	Санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал	50	бага	96/176

Дээрх индексийн дэд хүчин зүйлсийг шалгуур үзүүлэлт болгон үнэлэхдээ дараах агуулгын хүрээнд хянадаг байна. Үүнд:

1.Өмчийн эрх - Хувь хүмүүс өмч эзэмших эрх чөлөө, эрсдэл, оюуны өмчийн хамгаалалт, газар эзэмших эрсдэл

2.Шүүхийн үр ашиг - Иргэдийг хэр сайн хамгаалагдаж байгааг харуулна.

3.Төрийн ёс зүй – Төрийн албаны авлига авах байдлыг үнэлдэг.

4.Татварын дарамт- Хувь хүмүүс болон аж ахуйн нэгжүүдэд татвар хэр их дарамт учруулж байгааг харуулна.

5.Засгийн газрын зарлага – Төсвийн алдагдал, хэт их зардал нь төсөвт хэр их дарамт учруулж байгааг харуулна.

6.Төсвийн сахилга бат – Засгийн газрын буруу менежментийг харуулна.

7.Бизнесийн эрх чөлөө – Бизнесийн үр ашигтай үйл ажиллагааг хэр зэрэг хязгаарлаж байгааг харуулна.

8.Хөдөлмөр эрхлэх эрх чөлөөт байдал – Хөдөлмөр эрхлэх боломжийн эрх чөлөөг харуулна.

9.Мөнгөний бодлогын чөлөөт байдал – Мөнгөний бодлогын үр дүнтэй байдал болон дотоодын инфляцын байдлыг дүгнэн үнэлдэг.

10.Чөлөөт худалдаа - Экспорт, импортод нөлөөлж буй тарифын болон тарифын бус саад бэрхшээлийг харуулна.

11.Хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал – Хөрөнгө оруулалтын эрсдэл, хөрөнгө оруулалтын урсгалд хэр их хязгаарлалт байгааг харуулна.

12. Санхүүгийн зах зээлийн нээлттэй байдал - Банкны үйл ажиллагааны үр ашгийг харуулна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад бодлогын болон бүтцийн өөрчлөлтүүд явагдаж, худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал өөрчлөгдөж байгаа энэ цаг үед дэлхийн улс төр, эдийн засгийн өрнөлд тодорхой бус байдал эрчимтэй нэмэгдэж байна. Тухайлбал, Дэлхийн тодорхой бус байдлын индексийн үзүүлэлт сүүлийн сард түүхэн дээд түвшинд хүрээд байна. ОУВС дэлхийн эдийн засгийн өсөлт 2025 онд 3.0 хувь, 2026 онд 3.1 хувь буюу цар тахлын өмнөх 3.7 хувийн дундаж өсөлтөөс бага байхаар төсөөлж байна. Худалдааны дайны цар хүрээ улам бүр тэлж болзошгүй байгаа нь дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах, инфляцыг өдөөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Манай улсын хувьд төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нэрлэсэн Дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа 2018, 2019 онуудад 29 хувь байсан бол 2023 онд 33 хувь, 2024 онд 37 хувь болж нэмэгдсэн. Засгийн газрын зүгээс цаашид уг харьцааг 2026 онд 30.9 хувь, 2027 онд 29.3 хувь, 2028 онд 28.2 хувь болгож үе шаттай бууруулахаар төлөвлөж байгаа ба ингэснээр хувийн хэвшлийг дэмжсэн татварын шинэчлэл хийгдэх орон зайг үүсгэж, хувийн хэвшлийн бизнесийг тэлэх боломжийг бүрдүүлэх, улмаар эдийн засаг дахь төрийн оролцоог үе шаттай бууруулна.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт 933 (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд 2025.09.08-ны өдрийн байдлаар байршсан тоо) хуулиас аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрх (бизнес, хөрөнгө оруулалт, худалдаа г.м)-тэй шууд болон шууд бус холбоотой харилцааг зохицуулсан ойролцоогоор 368 хууль үйлчилж байна. Эдгээр хууль нь тухайн салбарын харилцааг нарийвчлан зохицуулсан байх ба ингэхдээ аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хязгаарласан, хориглосон, нэмэлт шаардлага тавьсан, зайлшгүй шаардлагатайгаас бусад байдлаар зөвшөөрөл авахыг шаардсан зэрэг зохицуулалтууд нэлээдгүй байна.

Иймд хуулиар хориглосноос бусад аж ахуйн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх, өмчийн халдашгүй байдлыг хангаж, аж ахуйн үйл ажиллагаанд оролцогчдын эрх тэгш байдлыг хангах, гадаад, дотоодын зах зээлд чөлөөтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх, аж ахуйн үйл ажиллагаа дахь төрийн оролцоог багасгаж, зохицуулалтын үр нөлөөтэй байдлыг хангах зорилгоор аж ахуйн үйл ажиллагааны чиглэлээр төрийн байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомж, шийдвэрийг батлахдаа тус анхдагч хуулийг давуу хүчинтэй байдлаар баримтлах, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

Мөн дээр дурдсан “Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индекс”-ээр хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал, зохицуулалтын үр ашигтай байдлыг тооцохдоо бизнесийн үр ашигтай үйл ажиллагааг хэр зэрэг хязгаарлаж байгааг тооцдог талаар дурдсан байх ба хөрөнгө оруулагчийн эрх ашиг сонирхлыг хамгаалах, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд төрөөс үзүүлэх дарамтыг багасгах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор зөвшөөрлийн процессыг хялбаршуулах, цахимжилтыг эрчимжүүлэх зорилгоор Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төслийг дагаж Хөрөнгө оруулалтын тухай, Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Монгол Улсад 1990 оноос 2025 оны I дүгээр улирал хүртэл нийт 48.95 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирснээс 74 хувь нь уул уурхайн олборлолт, 10 хувь нь худалдаа, үйлчилгээний салбарт хийгдсэн бол бусад салбарууд нийлээд 16 хувийг эзэлж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт төрөлжихгүй, зөвхөн нэг салбарт харьцангуй ихээр төвлөрч байна. Уул уурхайн олборлолт, бүтээн байгуулалттай холбоотойгоор сүүлийн 10 жилийн дунджаар

гадаадын шууд хөрөнгө оруулалтын 42 хувийг “Оюутолгой” ХХК дангаар бүрдүүлж байгаа ба 2024 оны гадаадын шууд хөрөнгө оруулалтын 80 хувь нь уул уурхайн салбарт хамаарч байна. Аж ахуйн нэгжийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэлбэрээр ялгаварласан, үйл ажиллагаа явуулахыг хориглосон, хязгаарласан зохицуулалт болон төрийн үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, хүсэлтээ шийдвэрлүүлэх хугацаа, төлбөр хураамжийг ялгамжтай тогтоосноос шалтгаалан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд хараат болон охин компани, компанийн нэгдлийг байгуулж байгаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодит үр өгөөжийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлоход хүндрэл үүсгэсээр байна.

Жишээ дурдвал, Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарлаж, хориглосон, эсхүл гадаадын иргэн, хуулийн этгээдэд нэмэлт шаардлага тавьсан нийт 40 гаруй хууль байх бөгөөд эдгээрээс зүй ёсны буюу байх ёстой шаардлагыг тогтоосон хуулиудаас гадна гадаадын иргэн, хуулийн этгээдийг Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгө оруулах боломжийг хязгаарласан, хориглолт тогтоосон, ач холбогдолгүй нэмэлт шаардлагыг бий болгосон хэд хэдэн хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь эдийн засгийн бүх салбар, үйл ажиллагааг хамарсан өргөн хүрээний асуудал тул хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр төрийн байгууллагын уялдаа холбоог хангах шаардлагатай юм.

Түүнчлэн Улсын Их Хурлаас 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хуулийг баталж, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан 1000 гаруй төрлийн тусгай зөвшөөрлийн тоог 14 чиглэлийн салбарт **251** “тусгай зөвшөөрөл”, **130** “энгийн зөвшөөрөл”, нийт **381** төрлийн зөвшөөрөл болгон бууруулж хуульчилсан. Зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд нийт **16** зөвшөөрлөөр буюу боловсролын салбарт 4, байгаль орчны салбарт 3, банк, санхүүгийн салбарт 2, хүнс, хөдөө аж ахуйн салбарт 2, батлан хамгаалах салбарт 2, хууль зүйн салбарт 1, аймаг, нийслэлийн засаг даргаас олгох 2 зөвшөөрөл тус тус нэмэгдсэн байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлд эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, энэ хуульд өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлох, зөвшөөрөл шинээр бий болгох, олгох үйл ажиллагаанд холбогдох санал, зөвлөмж гаргуулах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл Ерөнхий сайдын дэргэд ажилладаг бөгөөд уг зөвлөлөөс зөвшөөрөл олгох зарим эрх бүхий байгууллагууд энэ процессыг алгасаж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зөрчлүүд байна.

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд дурдсанаар Зөвшөөрлийн тухай хуулиар салбар бүрийн зөвшөөрөл олголтын процессийг нарийвчлан зохицуулах боломжгүй бөгөөд салбарын хуулиар энэ төрлийн харилцааг хуульчилж өгөөгүйтэй холбоотойгоор салбар бүр захиргааны хэм хэмжээний акт батлан зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулж байгаа нь тус хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт заасан “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасантай зөрчил үүсгэж байна.

Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцаа хуульчлагдсан болон захиргааны хэм хэмжээний акт, журмаар зохицуулж байгаа байдлыг судалж үзэхэд, нийт **251** тусгай зөвшөөрлөөс **89** тусгай зөвшөөрөлд

хамаарах харилцаа нь эрх бүхий байгууллагаас батлагдсан захиргааны хэм хэмжээний акт, журмаар, **33** зөвшөөрөлд хамаарах харилцаа нь хууль болон захиргааны хэм хэмжээний акт, журмаар давхардсан байдлаар зохицуулагдаж байгааг дурджээ. Өөрөөр хэлбэл нийт **251** төрлийн тусгай зөвшөөрлийн **122** зөвшөөрөлд хамаарах харилцааг захиргааны хэм хэмжээний акт, журмаар зохицуулж байна гэсэн судалгааны дүн гарсны дагуу Зөвшөөрлийн зөвлөлөөс Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тус хуулийн зохицуулалтад салбарын хууль тогтоомж, журмуудыг нийцүүлэх чиглэлээр холбогдох дүгнэлт, зөвлөмжийг зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагуудад хүргүүлсний дагуу эрх бүхий байгууллагуудаас нийт 60 гаруй захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, зарим зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг хэрэгжүүлсэн.

Хууль тогтоомжид зөвшөөрөл гэж нэрлэгдээгүй боловч бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд шаарддаг, төрийн байгууллагаас олгодог баримт бичгүүдийг Төрийн хэмнэлт, бүтээмжийн зөвлөлөөс судалж үзэхэд Монгол Улсын хуулиудад бүртгэл 264, дүгнэлт 232, гэрчилгээ 132, магадлан итгэмжлэл 30, сертификат 9 байна гэсэн үр дүн гарч, зөвшөөрөл олгох процесстой адилхан процессыг бүрдүүлж байгаа нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан “Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай болон энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно.” гэж заасантай зөрчил үүсгэж байна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн, хуулийн этгээд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхээ хэрэгжүүлэхэд төрөөс баримтлах зарчим, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам болон төрийн байгууллагын хүлээх үүргийг тодорхойлж, хувийн аж ахуй эрхлэх эрхийг баталгаажуулахад оршино.

Хуулийн төслийг дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагад үндэслэн дараах агуулгаар боловсруулсан болно.

➤ Эдийн засгийн эрх чөлөөг хангахад баримтлах зарчмыг тодорхойлох:

Монгол Улсын Үндсэн хуулийн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, 16 дугаар зүйлийн 16.4-т “...хувийн аж ахуй эрхлэх эрхтэй” гэж тус тус заасан.

Иймээс төрийн зүгээс иргэн, хуулийн этгээдийн эрхлэх аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой харилцаанд оролцохдоо баримтлах нийтлэг зарчмуудыг тодорхой тусгасан бөгөөд тэдгээр зарчмыг төрийн бүх шатны байгууллагууд болон хувь хүн, байгууллага (зохих хэмжээнд) дагаж мөрдөх үүргийг хүлээхээр зохицуулна.

➤ Эдийн засгийн эрх чөлөөг хангах баталгааг бүрдүүлэх:

Энэхүү хуульд тусгасан зарчмыг хэрэгжүүлэх арга замыг тодорхой нарийвчлан зохицуулах бөгөөд одоогийн хууль тогтоомжийн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулахад чиглэсэн зохицуулалтуудыг тусгана.

➤ Эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлах, хориглосон хуульд тавигдах шаардлагыг нарийвчлан зохицуулах:

Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн эдийн засгийн эрх чөлөөг төрийн зүгээс

хязгаарлах, хориглох арга хэмжээг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд ингэхдээ тус хуулийн төслийг боловсруулах, батлахад тавигдах шаардлагыг тодорхой, хоёрдмол утгагүй зохицуулна.

Жишээлбэл, хуулийн төсөлд тавигдах шаардлага буюу хязгаарласан, хориглосон зохицуулалтын хүрээ, агуулга болон төслийг олон нийтэд танилцуулах, оролцоог нь хангах, санал авах, мэдээлэхтэй холбоотой харилцааг тодорхой тусгаж, иргэн, хуулийн этгээдийн мэдэх эрхийг бүрэн хангана.

➤ **Төрөөс аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэгийг тусгах:**

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэсний дагуу төрийн зүгээс аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, харилцан туслалцах замаар улсынхаа эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.

Иймд энэхүү хуулийн төсөлд төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэн хөгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд түргэн, шуурхай хүргэх, харилцан мэдээлэл солилцох зэргээр тэдгээрийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн агуулгатай нийтлэг зохицуулалтыг тусгана.

Гурав. Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Энэ хуулийн төсөл батлагдсанаар дараах эдийн засаг, нийгэм, хууль зүйн эерэг үр дагаврыг бий болгоно. Үүнд:

1/Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтны зүгээс нэгдсэн бодлого, зарчмыг баримтлан иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаанд оролцох буюу тэдгээрийг дур зоргоороо шийдвэр гаргах боломжийг хязгаарлана.

2/Хууль, шүүхийн байгууллагаас бизнес, хөрөнгө оруулагч, худалдаа эрхлэгчийн аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой маргааныг хянан шийдвэрлэхэд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бий болгоно.

3/Иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаа дахь төрийн оролцоог бууруулж, өрсөлдөөнт, чөлөөт зах зээлийн эдийн засаг бүрэн утгаараа хөгжих боломж бүрдэнэ.

4/Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал нөлөөлөл үзүүлнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал:

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй уялдуулан Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсүүдийг хамтад нь боловсруулна.